



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянговь сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/15/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд

тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584

Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424

Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: Г.Ганчимэг

Утас: 88268424

Цахим хаяг: ganaa_7133@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан.....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, АРГА зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	8
2.8.1 Мөнгөн хөрөнгө	8
2.8.2 Авлага	9
2.8.3 Бараа материал	9
2.8.7 Үндсэн хөрөнгө	10
2.8.8 Өр төлбөр.....	10
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	11
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	14
2.12. Шилэн дансны мэдээлэл	14
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	14
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	14
1. Менежментийн захидал	15
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	17
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	17
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	18
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	21
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	24
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	24
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail: bayankhongor@audit.gov.mn

᠒᠐᠒᠐.᠐3.᠒3 № 1/357

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ 7

Г БАЯНГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГА 7
Б.ЭРДЭНЭБИЛЭГ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 8.9.3-д заасны дагуу Баянговь сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянговь сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянговь сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\ 005020286

хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Баянговь сумын Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ



D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2. Аудитын тайлан

2.1. ОРШИЛ

Баянговь сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Б.Эрдэнэбилэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 8.9.3-т заасны дагуу Баянговь сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянговь сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 20-ноос 2020 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ганчимэг гүйцэтгэв.

Баянговь сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 24 -ны өдрийн 34 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.-

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе

шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Баянговь сумын Засаг даргын харьяаны төсөвт байгууллагууд нь санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх шаардлагатай гэж үзсэн байна.

Баянговь сумын Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Баянговь сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудаас хяналт шалгалт хийгээгүй байна.

Төрийн аудитын байгууллагаас эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр				
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэж дүгнэлт гаргасан	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	2	4	-	2	-
	Дүн	2	4	-	2	-

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянговь сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг аудитор гүйцэтгэлээ.

Баянговь сумын Засаг дарга санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Засгийн газрын санхүүгийн "Э-тайлан" программ хангамж ашигладаг байна.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэн 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2025393,5 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 20253,9 мянган төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2321682,2 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 23216,8 мянган төгрөгөөр тооцсон бөгөөд төлөвлөлтийн шатанд тооцсон материаллаг байдлаас 2962,9 мянган төгрөгөөр өссөн нь төлөвлөлтийн шатанд 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг татсантай холбоотой байна.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 8 байгууллага аудитад хамрагдсан байна. Үүнээс:

№	Байгууллагын нэр	Дүгнэлтийн хэлбэр	Аудитад хийсэн байгууллага нэр
1	ЗДТГ	Зөрчилгүй	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар
2	Эрүүл мэндийн төв	Зөрчилгүй	
3	Ерөнхий боловсролын сургууль	Зөрчилгүй	
4	Цэцэрлэг	Зөрчилгүй	"Хонгорын үр сад" ХХК
5	ИТХ		
6	Соёлын төв	Түүвэрт хамрагдсан	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар
7	Орон нутгийн хөгжлийн сан		
8	Сум хөгжүүлэх сан		

Баянговь сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 172.1 төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 171,1 сая төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 0.7 сая сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүллээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн эхний, эцсийн үлдэгдлийг тулган шалгахад харьяа байгууллагуудын Э-тайланд шивсэн тайлан нь аудитлагдсан тайлантай тохирч байгаа эсэхийг тулган шалгаагүй баталгаажуулж, нэгтгэсэн санхүүгийн тайланг Э-тайланд зөрүүтэй оруулсан тайлангаас нэгтгэлийг хийснээс шалтгаалж байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- ❖ Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 24,1 сая төгрөгөөр орлого, зарлагыг илүү / дутуу/, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 48,8 сая төгрөгөөр дутуу, хөрөнгийн орлогыг 48,8 сая төгрөгөөр илүү нэгтгэсэн

- ❖ Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд 0,03 сая төгрөгөөр орлого илүү, 98,3 сая төгрөгөөр биет бус хөрөнгө худалдаж авсан зардлыг дутуу, үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/ зардлыг илүү 98,3 сая төгрөгөөр нэгтгэсэн;

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

ТТЗ-чийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар акт тогтоогоогүй, албан шаардлага өгөгдөөгүй.

Төвлөрүүлсэн захирагчид 0,7 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 2 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Цэцэрлэгийн санхүүгийн тайланд:

1. Хөрөнгийн дахин үнэлгээгээр хөрөнгийг 62410,7 мянган төгрөгөөр үнэлснийг санхүүгийн тайланд тусгахдаа дахин үнэлгээний бууралт 93542,9 мянган төгрөгийг дахин үнэлгээний нэмэгдлээр бүртгэж өмнөх оны аудитлагдсан тайлангийн эцсийн үлдэгдлийг тайлант онд зөрүүтэй тусгаж, дээрх зөрүүг тайланд барилга байгууламжийн хуримтлагдсан элэгдлийн дансанд бүртгэж зассан байсныг залруулав.

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр ашиглалтад орсон Цэцэрлэгийн барилгын ажлыг улсын комисс хүлээн авсан боловч хөрөнгийг бүртгэлд тусгах ТӨБЗГ-ын тогтоол гараагүй байхад санхүүгийн тайланд 1225149,8 мянган төгрөгөөр бүртгэснийг тус тус залруулав.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчил 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 926,5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.

Төсвийн шууд захирагчийн тайланд илэрсэн алдаа, зөрчил /сая.төг/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн		Үүнээс					
		Тоо	Дүн	Зөвлөмж		Төлбөрийн акт		Албан шаардлага	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ЗДТГ	3	792.9	1	0.1			2	792.8
2	Ерөнхий боловсролын сургууль	1	1.4			1	1.4		
3	Цэцэрлэг	1	0.8			1	0.8		
4	Эрүүл мэндийн төв	2	1.4	1	1.3	1	0.1		
5	Сум хөгжүүлэх сан	1	47.3			1	47.3		
6	Орон нутаг хөгжүүлэх сан	2	82.7	2	82.7				
	ДҮН	10	926.5	4	84.1	4	49.6	2	792.8

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Төрийн сан, арилжааны банкны мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 178189.4 мянга, эцсийн үлдэгдэл 166553.5 мянган төгрөг болж 12635.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Эцсийн үлдэгдлийн эзлэх хувь
Орон нутгийн ерөнхий орлого	59099.7	51920.6	-7179.1	31.3%
Орон нутгийн хөгжлийн сан	29882.6	1805.1	-28077.5	1.1%
Сум хөгжүүлэх сан	89177.4	111798.1	22620.7	67.6%
Арилжааны банкны үлдэгдэл	29.7	29.7	0	0.0%
Дүн	178189.4	166553.5	-12635.9	100.0%

Эх сурвалж: Баянговь сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 165553,5 мянган төгрөг нь дээрх харилцах дансанд байршиж байна. Үүнээс Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 51920,6 мянган төгрөгийн үлдэгдлээс 5224,9 мянган төгрөг нь оны эцэст төсөвт байгууллагуудад орон нутгийн орлогоос санхүүжүүлсэн зарцуулаагүй үлдэгдлийг төвлөрүүлсэн, 46695,7 мянган төгрөг нь урьд оны зарцуулаагүй үлдэгдэл байна.

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 136579,3 мянга, эцсийн үлдэгдэл 156775,1 мянга төгрөг болж 20195,7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	893.8	921.2	27.4
Байгууллагаас авах авлага	14800.0	54713.0	39913.0
Зээлийн хүүгийн авлага	120885.5	101140.9	-19744.6
Дүн	136579.3	156775.1	20195.7

Эх сурвалж: Баянговь сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага өмнөх оноос 20195,7 мянган төгрөгөөр өссөний гол шалтгаан нь сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажилд олгосон 52500,0 мянган төгрөгийн авлага, СХС-аас олгосон зээлийн хүүгийн тайлант оны 3321,0 мянга төгрөгийн авлага, эрүүл мэндийн төв нь Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын 2144,1 мянган төгрөгөөр илүү шилжүүлсэн шинээр нэмж авлага үүссэнтэй холбоотой байна.

Авлагын үлдэгдлийг аудитаар судалж үзэхэд олон жилийн насжилттай дараах авлага байна.

Үүнд: Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй хугацаа хэтэрсэн зээлийн авлага 47300,0 мянган төгрөгийн байна.

2.8.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 174339.4 мянга, эцсийн үлдэгдэл 231428.7 мянган төгрөг болж, 57089.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	5,159.5	14,840.3	9,680.8
Бэлэн бүтээгдэхүүн	111.0	-	-111.0
Бичиг хэргийн материал	8,721.0	5,931.3	-2,789.6
Аж ахуйн материал	95,325.0	110,775.5	15,450.5
Түлш, шатах тослох материал	428.5	190.0	-238.5
Барилгын засварын материал	1,020.0	15,748.0	14,728.0
Хүнсний материал	894.8	3,503.7	2,608.8
Бусад хангамжийн материал	39,207.9	60,553.1	21,345.2
Мал амьтад	10,314.0	20,314.0	10,000.0
Бусад нөөц	1,151.5	-	-1,151.5
Дүн	162,333.2	231,855.8	69,522.6

Эх сурвалж: Баянговь сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд хандив тусламж, шилжүүлэн авсан 46114,7 мянга, төсвийн хөрөнгөөр 296795,8 мянган төгрөгийн бараа материал авч, данс хооронд 2277,3 мянган төгрөгийн бараа материал шилжүүлж 247407,5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Хүснэгт №3.1 материалын дэлгэрэнгүй /мянган төгрөг/

№	Байгууллага	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн					Хасагдсан				Бүгд	Эцсийн үлдэгдэл
			Төсвийн хөрөнгөөр	Хандив тусламжаар	Шилжүүлэн авсан	Шилжүүлсэн авсан бүтцийн өөрчлөлт	Бусад	Бүгд	Худалдсан, зарцуулсан	Шилжүүлсэн авсан бүтцийн өөрчлөлтөөр	Бусад		
1	ИТХурал	3,494.0	4,225.6	-	-	2,277.3	-	6,502.9	4,165.6	2,277.3	468.0	6,910.9	3,086.0
2	ЗДТГазар	48,352.5	38,753.4	24,832.7	10,000.0	-	-	73,586.1	53,220.2	-	6,344.1	59,564.3	62,374.2
3	Сургууль	51,937.8	116,517.6	10,687.2	-	-	5.0	127,209.8	90,140.8	-	10,189.0	100,329.8	78,817.8
4	Цэцэрлэг	26,842.9	57,733.4	589.8	-	-	-	58,323.2	33,340.8	-	2,550.0	35,890.8	49,275.4
5	Соёл	19,374.3	12,248.5	-	-	-	-	12,248.5	2,561.5	-	6,429.3	8,990.8	22,632.0
6	ЭМТөв	12,331.7	67,317.3	-	-	-	-	67,317.3	63,978.6	-	-	63,978.6	15,670.4
	Дүн	162,333.2	296,795.8	36,109.7	10,000.0	2,277.3	5.0	345,187.8	247,407.5	2,277.3	25,980.4	275,665.2	231,855.8

2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4722503.4 мянга, эцсийн үлдэгдэл 4724215.1 мянган төгрөг болж, 1711.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	2,483,319.8	4,285,066.0	1,801,746.2
Тээврийн хэрэгсэл	163,354.2	194,760.0	31,405.8
Машин тоног төхөөрөмж	421,801.8	487,319.5	5,517.8
Тавилга эд хогшил	230,514.4	222,953.8	(7,560.6)
Зам гүүр байгууламж	199,800.0	199,800.0	
Дуусаагүй барилга, байгууламж	901,382.4	-	(901,382.4)
Номын фонд	29,815.7	6,673.7	3,142.0
Бусад үндсэн хөрөнгө	214,845.2	285,068.3	70,223.0
Программ хангамж	3,490.0	1,750.0	(1,740.0)
Бусад биет бус хөрөнгө	64,700.0	64,700.0	-
Дүн	4,713,023.4	5,768,091.3	1,055,067.8

Эх сурвалж: Баянговь сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 98967,3 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, үнэ төлбөргүй, хандив тусламжаар, балансаас шилжүүлж нийт 2130255,8 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн ба 39656,2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж орон нутгийн өмчийн газраас худалдан борлуулсан ба 868382,4 мянган төгрөгийн хөрөнгийг дуусаагүй үйлдвэрлэл данснаас үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлж 266116,7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж хасагдсан байна.

Хүснэгт №4.1- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй /мянган төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Төсвийн болон өөрийн хөрөнгийн эхүүсвэрээр худалдаж авсан	Үнэ төлбөргүй хандив, тусламжаар авсан	Худалдсан	Акталсан	Балансаас балансад шилжүүлж өгсөн	Эцсийн үлдэгдэл
Сургууль	1,535,273.9	59,063.5	49,811.1	-	79,017.3	-	1,565,131.2
Цэцэрлэг	131,899.1	3,900.0	550.0	-	7,868.0	-	128,481.1
Эрүүл мэндийн төв	468,909.3	11,303.9	5,600.0	-	101,278.6	-	384,534.6
Соёлын төв	937,293.6	-	1,129,634.7	-	13,194.4	868,382.4	1,185,351.5
ИТХ	14,316.4	3,000.0	-	-	2,960.1	-	14,356.3
ЗДТГ	1,625,331.2	21,699.9	944,660.0	39,656.2	61,798.3	-	2,490,236.6
Дүн	4,713,023.4	98,967.3	2,130,255.8	39,656.2	266,116.7	868,382.4	5,768,091.3

2.8.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 759,4 мянга, эцсийн үлдэгдэл 2763,5 мянган төгрөг болж, 2004,0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан
Богино хугацаат өр төлбөр дүн	759.4	2763.5	385.4
Ажилчидтай холбогдсон өглөг	95.0	618.7	523.7
Бараа үйлчилгээний зардлын өглөг	14.4	182.9	168.5
Байгууллагад төлөх өглөг	650.0	1306.0	656.0
Хувь хүмүүст төлөх өглөг	0.0	655.9	655.9
Урт хугацаат өр төлбөр дүн	0.0	0.0	0.0
Нийт дүн	759.4	2763.5	385.4

Эх сурвалж: Баянговь сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Оны эхний болон эцсийн богино хугацаат өр төлбөрийн үлдэгдлийн дийлэнх хувийг ажиллагсадтай холбоотой өглөг эзэлж байгаа нь төсөвт байгууллагын төсвийн захирагч, нягтлан бодогч нар Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т заасан “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажилладаггүй, НДШ-д 1207,1 мянга, ХХОАТ-т 56,4 мянган төгрөгийн өглөг шинээр үүссэн байна.

Тухайлбал:

- Ерөнхий боловсролын сургууль оны эцэст НДШ-ын 655,9 мянга, шатахуунд-111,1 мянга, бусад зардалд 27,3 мянган төгрөгийн өглөгтэй гарсан;
 - Цэцэрлэг оны эцэст 305,0 мянган төгрөгийн НДШ-ын, 44,4 мянган төгрөгийн хоолны зардлын өглөгтэй гарсан;
 - Соёлын төвийн оны эцэст 56,4 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөгтэй гарсан;
 - ИТХ-ын хурал НДШ-ын 257,2 мянган төгрөгийн өглөгтэй гарсан;
- Цаашид батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж төсөвтөө багтаан ажиллаж, оны эцэст өглөггүй ажиллах шаардлагатай байна.

Хүснэгт 5.1 Өглөгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

№	Төсвийн захирагч	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс:		
				Ажиллагсадтай холбоотой	Байгууллага хоорондын	Бусад
1	Сургууль	14.4	794.4	0.0	655.9	138.5
2	Цэцэрлэг	0.0	349.4	305.0	0.0	44.4
3	Соёлын төв	0.0	56.5	56.5	0.0	0.0
4	ИТХ	0.0	257.2	257.2	0.0	0.0
5	ЗДТГ	95.0	6.0	0.0	6.0	0.0
6	СХС	650.0	1300.0	0.0	1300.0	0.0
	Дүн	759.4	2763.5	618.7	1961.9	182.9

Эх сурвалж: Баянговь сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4449376,2 мянга, эцсийн үлдэгдэл 5356699,2 мянган төгрөг болж, 748751,9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	1248819.7	1248819.7	0.0	23.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1398359.0	1239787.9	-158571.0	23.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	158571.0	0.0	3.0
Хуримтлагдсан үр дүн	1802197.6	2868091.6	1065894.0	53.5
Дахин үнэлгээний нөөц	0.0	-158571.0	-158571.0	-3.0
Дүн	4,449,376.27	5,356,699.25	748,751.92	100

Эх сурвалж: Баянговь сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын капитал дансанд өөрчлөлт ороогүй бөгөөд дахин үнэлгээний үлдэгдэлтэй хөрөнгө акталснаас хөрөнгийн дахин үнэлгээний данс 158571,0 мянган төгрөгөөр буурч байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Аймгийн ИТХ-ын 2018 оны төсөв батлах тухай 10/03 дугаар тогтоолд зааснаар Баянговь сумын Засаг дарга тайлант онд улсын төсөвт 8000,0 мянга, аймгийн төсөвт 132700,0 мянга, нийт 140700,0 мянган төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 142963,7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 101,6 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого / мянган төгрөг /

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1. Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	8000.0	5433.5	-2566.5	67.9
1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	4000.0	3701.0	-299.0	92.5
1.2. Нэмэгдсэн өртгийн албан татвар	2500.0	678.8	-1821.2	27.2
1.3. Агаарын бохирдлын төлбөр	1500.0	1053.7	-446.3	70.2
2. Аймгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого	132700.0	137530.2	4830.2	103.6
2.1. Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	113000.0	113092.3	92.3	100.1
2.2. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	1200.0	2071.4	871.4	172.6
2.3. Газрын төлбөр	5000.0	6676.6	1676.6	133.5
2.4. Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар	13500.0	15689.9	2189.9	116.2
Нийт дүн	140700.0	142963.7	2263.7	101.6

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн татварын орлогын мэдээ

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 67,9 хувиар биелүүлж 32.1 хувиар тасарсан нь аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаа эрхлэлтийн орлогоос шалтгаалж, аймагт төвлөрүүлэх орлогыг 101.6 хувиар биелүүлсэн байна.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2018.12.17-ний өдрийн 10/02 тоот тогтоолоор сумд төвлөрөх татварын орлогыг 36300,0 мянга, татварын бус орлогыг 4100,0 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 48593,1 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 113 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 9. Сумын орон нутгийн орлого / мянган төгрөг /

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1. Татварын орлого	36,300.0	41,664.6	5,364.6	115
1.1. ИОТХ	6,000.0	7,109.2	1,109.2	118
1.2. Хадгаламжийн хүүгийн орлого	14,000.0	20,689.0	6,689.0	148
1.3. ҮХЭХХБОАТ	-	40.0	40.0	
1.4. Бууны татвар	1,800.0	1,950.0	150.0	108
1.5. Улсын тэмдэгтийн хураамж	2,200.0	1,256.2	-943.8	57
1.6. Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	11,500.0	9,208.9	-2,291.1	80
1.7. ТТАМАТөлбөр	300.0	350.0	50.0	117
1.8. Ус ашигласны		100.0	100.0	
1.9. Нохойны татвар	500.0	961.3	461.3	192
2. Татварын бус орлого	3,000.0	5,385.5	98.9	180
2.1 Хүү торгуулийн орлого	3,000.0	5,385.5	2,385.5	180
ТӨӨ	4,100.0	1,813.4	-2,286.6	44
Нийт дүн	43,400.0	48,863.5	3,176.9	113

Эх сурвалж: Баянговь сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт зориулан 2255921,6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2034845,7 мянган төгрөгийг урсгал зардалд, 168407,2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1302433,2 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 28929,7 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс, 627058,1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 105607,2 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 74419,1 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 117474,3 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтийг бүрэн авч, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс 7195,9 мянга, орон нутгийн төсвөөс ЗДТГ-ын газар орлогын төлөвлөгөө биелээгүй учраас 8070,4 мянга төгрөгийн санхүүжилт дутуу авсан, мөн өмнөх оны авлага 5000,0 сая төгрөгийг барагдуулж орон нутгаас авах санхүүжилтийг дутуу авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоор сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтийн орлогоор 34152,6 мянган төгрөг оруулахаас 23715,6 мянган төгрөг оруулж, батлагдсан төсвөөс 10436,9 төгрөгөөр тасарсан нь Сум хөгжүүлэх сангийн зээлийн төлөлт хангалтгүй байгаатай холбоотой ба тайлант онд шинээр зээл олгоогүйтэй байна.

Туслах үйл ажиллагааны орлогоор сумын ЗДТГ-ын 600.0 мянга, соёлын төв 3500,0 мянга, Орон нутгийн хөгжлийн санд 36166,5 мянга нийт 40266,5 мянган төгрөг төвлөрүүлэхээс Соёлын төв 1813,4 мянга, ОНХС-д 26170,9 мянга нийт гүйцэтгэлээр 27984,3 мянган төгрөг оруулж, төлөвлөгөө 12282,1 мянган төгрөгөөр тасарсан байна.

Иймд цаашид сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтөд онцлон анхаарч ажиллаж, төсөвт байгууллагууд өөрийн орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж ажиллах, орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг бодиттой төлөвлөх шаардлагатай байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2094712,1 төгрөг буюу 92,8 хувьтай байгаа нь цалингийн зардал 1465,9 мянга, ндш-зардал 5524,7 мянга, тогтмол зардал 4674,8 мянга, хангамж, бараа материалын зардал 3164,6 мянга, норматив зардал 2932,4 мянга, эд хогшил худалдан авах зардал 6275,3 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн, Сум хөгжүүлэх сангаас тайлант онд зээл олгоогүйгээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 126346,1 мянган төгрөгөөр хэмнэгдсэн зэрэг нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Хүснэгт 10. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	61749.3	61,749.3	0	100.0
Засаг даргын Тамгын газар	317355.1	308,897.6	-8457.4	97.3
Ерөнхий боловсролын сургууль	869904.9	866014.2	-3890.6	99.6
Цэцэрлэг	243944.1	241932.4	-2011.6	99.2
Соёлын төв	98670.2	96424.2	-2245.9	97.7
Эрүүл мэндийн төв	370897.4	358743.6	-12153.7	96.7
Сум хөгжүүлэх сан	124993.4	1095.0	-123898.4	0.9
Орон нутгийн хөгжлийн сан	168407.2	159855.6	-8551.5	94.9
Нийт дүн	2255921.6	2,094,712.1	-161209.4	92.9

Эх сурвалж: Баянговь сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нэмэлт төсөв: Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 7300,0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтээр олгож бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын ангилалд зарцуулах эрхийг нээж олгосон бөгөөд хөтөлбөр зориулалтын дагуу 100 хувь зарцуулсан байна.

БНА-2020/15/СТА-ТТЗ

Хүснэгт 11. Нэмэлт төсвийн судалгаа /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Санхүүжилт	Зарцуулалт
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1000.0	1000.0
Засаг даргын Тамгын газар	5200.0	5200.0
Соёлын төв	1100.0	1100.0
Нийт дүн	7300.0	7300.0

Эх сурвалж: Баянговь сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

2.12. Шилэн дансны мэдээлэл

Баянговь сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 116 мэдээллийг хугацаанд нь, 27 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	3	14	10	2	2
2	Хагас жил	3	3	3		
3	Улирал бүр	2	8	8		
4	Сар бүр	5	60	44	16	
5	Тухай бүр	5	60	51	9	
6	Нийт	18	145	116	27	2

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Баянговь сумын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд гэрээт аудитор Ш.Даваабат аудит хийж, аудитаар акт, албан шаардлага зөвлөмж өгөөгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянговь сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянговь сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

1. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянговь сумын Засаг даргын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Орлогын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Орон нутгийн татварын орлогын гүйцэтгэлийг татварын байцаагч болон санхүү албан дарга нар сар бүр тооцоо нийлж баталгаажуулдаггүй улмаас татварын мэдээ 25,0 мянган төгрөгөөр зөрүүтэй гаргасан. мөн 795,6 мянган төгрөгийн орлогыг Жаргалант сумын татварын дансанд буруу хааж орлогын гүйцэтгэлийг мэдээлээгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал, гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 “Нягтлан бодох бүртгэлд аж ахуйн бүх ажил, гүйлгээ, бүх орлого заавал бүртгэн” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл: Орон нутгийн орлого гүйцэтгэл буруу илэрхийлэгдэх өглөг авлага үүсэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Татварын орлогын гүйцэтгэлийг сар бүр төрөл тус бүрээр, харилцагчаар тооцоо нийлж, баталгаажуулж, орлогын төвлөрүүлэхдээ орлогын дансанд тухай бүр төвлөрүүлж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

3.2 Санхүүгийн тайлагналтай холбоотой

3.2.1 Илрүүлэлт:

Сумын Засаг даргын харьяаны байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгэж гаргахдаа санхүү албаны дарга нь нэгтгэж буй байгууллагуудын санхүүгийн тайланг Сангийн яамны Э-тайланд аудитлагдсан тайлангаас зөрүүтэй шивсэн байхад шалгаж БНА-2020/15/СТА-ТТЗ

